



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 04

Баянбулаг

Санг өөрчлөн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 40 дүгээр тогтоолын 1.1дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 81 дүгээр тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IX дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Суманд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор сум хөгжүүлэх санд төвлөрсөн хөрөнгийг зарцуулах сум хөгжүүлэх санг, хоршоо хөгжүүлэх сан болгон өөрчилсүгэй.

2.Холбогдох хууль тогтоомж журмын хүрээнд өөрчлөн шинэчлэгдсэн хоршоо хөгжүүлэх санг удирдлага зохион байгуулалтаар ханган үр дүнд хүргэж ажиллахыг сумын Засаг дарга (Н.Гансүх)-д даалгасугай.

ДАРГА  Б.НАМГАРРЕНЧИН



648803012